

“Нээлттэй Төсвийн Судалгаа-2015” дахь Монгол Улсын дүнг танилцуулах хэвлэлийн бага хурал хийлээ


Нээлттэй Нийгэм Форумгаас Дэлхийн 100 гаруй улс орны төсвийн ил тод, хариуцлагатай байдал ба төсвийн үйл явц дахь иргэдийн оролцоог хэмждэг “НЭЭЛТТЭЙ ТӨСВИЙН СУДАЛГАА-2015” дахь Монгол Улсын дүнг танилцуулах Хэвлэлийн бага хурал 2015 оны 9 дүгээр сарын 11-ний 11 цагт MN-25 телевизийн хэвлэлийн танхимд боллоо.

Хэвлэлийн мэдээ
Улаанбаатар, 2015 оны 9 дүгээр сарын 11

**Дэлхийн улс орнуудын төсвийн ил тод байдал ба иргэдийн оролцооны түвшинг
тодорхойлдог “НЭЭЛТТЭЙ ТӨСВИЙН СУДАЛГАА 2015” дахь Монгол Улсын дүнг
танилцуулж байна**

“Нээлттэй төсвийн судалгаа 2015”-ын дүнгээс харахад Монгол улсын төв засгийн газрын төсвийн ил тод байдал хангалтгүй хэвээр байна.

Монгол улсын төсвийн нээлттэй байдлын түвшин



Монгол Улс “Нээлттэй төсвийн судалгаа”-нд анхнаас нь буюу 2006 оноос хамрагдаж ирсэн бөгөөд 5 дахь удаагаа оролцлоо. Судалгаагаар төв засгийн газрын төсвийн ил тод байдал хангалтгүй хэвээр байгаа нь харагдлаа. Тухайлбал, нийт авбал зохих 100 онооноос 2006 онд 18, 2008 онд 36, 2010 онд 60 оноо, харин 2012 онд 51 оноо авч өмнөх ахиулж байсан амжилтаасаа ухарсан бол 2015 онд ахиц гарсангүй 51 оноотой хэвээр байна.

“Нээлттэй төсвийн судалгаа”-ны хүрээнд төсвийн ил тод байдлыг үнэлэхээс гадна төсвийн үйл явц дахь олон нийтийн оролцоо болон төсвийн хяналтын түвшинг мөн тодорхойлдог.

“Нээлттэй төсвийн судалгаа 2015” дахь Монгол улсын дүн

Үзүүлэлт	Оноо
Төсвийн ил тод байдал (Нээлттэй төсвийн индекс)	51
Төсвийн үйл явц дахь олон нийтийн оролцоо	19
Төсвийн хяналт	
Хууль тогтоох байгууллагын зүгээс төсөвт тавих хяналт	70
Аудитын байгууллагын зүгээс төсөвт тавих хяналт	92

Төсвийн ил тод байдал

Монгол Улс төсвийн ил тод байдлын хувьд 51 оноо авсан нь Засгийн газар тухайн жилийн улсын төсөв, санхүүгийн үйл ажиллагааны талаар зөвхөн зарим мэдээллийг олон нийтэд өгдөг болохыг харуулж байна. Засгийн газар 2012 оноос хойш Батлагдсан төсвийн Иргэдэд зориулсан төсвийг нийтэлсэн, мөн Жилийн эцсийн тайлангийн иж бүрэн байдлыг сайжруулсан зэрэг ахиц дэвшил гаргасан. Гэвч Хагас жилийн тойм боловсруулаагүй, 2014 оны гүйцэтгэх засаглалын төсвийн төслийг бүрэн эхээр нь нийтлээгүй (Сангийн яам зөвхөн төсвийн тооцоолол бүхий хавсралтуудыг нийтэлсэн. Харин хууль тогтоох байгууллага төсвийн төслийг бүрэн эхээр нь нийтэлсэн) зэрэг ухралт гарсан байна.

2012 оноос хойш Засгийн газрын төсвийн мэдээллийн нээлттэй байдалд гарсан өөрчлөлт

Ахиц дэвшил	Ухралт
• Иргэдэд зориулсан төсвийг нийтэлсэн (батлагдсан төсвийн хувьд). • Жилийн эцсийн тайлангийн иж бүрэн байдлыг сайжруулсан.	• Хагас жилийн тойм боловсруулаагүй. • 2014 оны гүйцэтгэх засаглалын төсвийн төслийг бүрэн эхээр нь нийтлээгүй.

Төсвийн үйл явц дахь олон нийтийн оролцоо

Засаглалыг сайжруулахад дан ганц төсвийн ил тод байдал хангалтгүй бөгөөд нээлттэй төсөвтэй холбоотойгоор гарах эерэг үр дүнг нэмэгдүүлэхийн тулд төсвийн үйл явцад олон нийтийн оролцоог хангах хэрэгтэй юм. Төсвийн үйл явц дахь олон нийтийн оролцооны хувьд Монгол Улс 19 оноо авсан нь Засгийн газар олон нийтэд төсвийн үйл явцад оролцох боломж олгохдоо маш хангалтгүй байгааг харуулж байна. Төсвийн үйл явцад олон нийт оролцох боломжийг гүйцэтгэх засаглал, хууль тогтоох болон аудитын дээд байгууллагын зүгээс төсвийн мөчлөгийн бүхий л шатанд олгох нь зүйтэй.

Төсвийн хяналт

Хууль тогтоох хийгээд аудитын дээд байгууллагууд улсын төсвийг төлөвлөх, хэрэгжилтэд хяналт тавихад чухал үүрэг гүйцэтгэдэг. Судалгаагаар эдгээр байгууллагын зүгээс төсөвт тавих хяналт хангалттай байгаа нь харагдлаа.

Хууль тогтоох байгууллагаас төсөвт тавих хяналт

Монгол улсын Хууль тогтоох байгууллагаас төсөвт тавих хяналт ерөнхийдөө хангалттай (70 оноо) байна. Цаашилбал, уг байгууллагын зүгээс төсөвт тавих хяналт нь төсвийн мөчлөгийн төлөвлөлтийн үе шатанд хангалттай, харин хэрэгжилтийн үе шатанд хязгаарлагдмал байна. Хуулийн дагуу ч тэр, бодит амьдрал дээр ч тэр

төлөвлөснөөс илүү төсвийн орлогыг шилжүүлэн ашиглах, нөөц сангийн хөрөнгийг зарцуулахдаа хууль тогтоох байгууллагаар батлуулдаггүй байна.

Аудитын байгууллагын зүгээс төсөвт тавих хяналт

Манай улсын Аудитын дээд байгууллагын зүгээс төсөвт тавих хяналт хангалттай (92 оноо) түвшинд байна. Хуулийн дагуу уг байгууллага нь өөрийн тохиромжтой гэж үзсэн хэлбэрээр аудит хийх эрх мэдэлтэй байна. Түүнчлэн аудитын дээд байгууллагын удирдлагыг хууль тогтоох буюу шүүх засаглалын зөвшөөрөлгүйгээр өөрчлөх боломжгүй байдаг нь тус байгууллагын хараат бус байдлыг хангахад чухал ач холбогдолтой. Аудитын дээд байгууллага өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах хангалттай нөөцтэй боловч чанарын баталгаажилтыг хангах тогтолцоо нь хязгаарлагдмал байна.

Зөвлөмж

Судалгааны дүнд тулгуурлан Монгол улсын гүйцэтгэх засаглал, хууль тогтоох болон аудитын дээд байгууллагуудад хандан дараах зөвлөмжийг гаргаж байна.

Төсвийн ил тод байдлыг сайжруулах талаар

Төсвийн ил тод байдлыг сайжруулахын тулд дараах арга хэмжээг нэн түрүүнд хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

- Хагас жилийн тойм, гүйцэтгэх засаглалын төсвийн төслийн иргэдэд зориулсан төсвийг боловсруулж, нийтлэх.
- Гүйцэтгэх засаглалын төсвийн төслийн иж бүрэн байдлыг нэмэгдүүлэх (Ирэх жилүүдийн зарлагын чиг үүргийн ангилал болон макро эдийн засгийн таамаглалын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэх).
- Жилийн эцсийн тайлангийн иж бүрэн байдлыг нэмэгдүүлэх (Төсвийн төлөвлөгөө болон гүйцэтгэлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг багтаах).

Төсвийн үйл явц дахь олон нийтийн оролцоог сайжруулах талаар

Төсвийн үйл явцад олон нийтийн оролцоог сайжруулахын тулд дараах арга хэмжээг нэн түрүүнд хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

- Төсөвтэй холбоотой асуудлаар олон нийтийн санал бодлыг авах итгэл хүлээсэн, үр дүнтэй механизм (жишээ нь, олон нийтийн сонсгол, судалгаа, зорилтот бүлгийн ярилцлага) бүрдүүлэх.
- Хууль тогтоох байгууллагын зүгээс тодорхой яам, газар, агентлагийн төсвийн талаарх сонсголыг зохион байгуулж, энэ үеэр олон нийтийн нотлох мэдүүлгийг сонсох.
- Аудитын шалгалтад олон нийтийн оролцоог хангах албан ёсны механизм бүрдүүлэх.

Төсвийн хяналтыг сайжруулах талаар

Төсвийн хяналтыг сайжруулахын тулд дараах арга хэмжээг нэн түрүүнд хэрэгжүүлэх нь зүйтэй. Үүнд:

- Төлөвлөснөөс илүү төсвийн орлогыг шилжүүлэн ашиглах, нөөц сангийн хөрөнгийг зарцуулахдаа хууль тогтоох байгууллагаар батлуулдаг болох.
- Хууль тогтоох байгууллагын зүгээс аудитын тайланг хэлэлцэх олон нийтийн уулзалтуудыг зохион байгуулах

Нээлттэй төсвийн судалгааг 2014 оны 3 дугаар сараас 2015 оны 9 дүгээр сар хүртэл нийт 18 сарын хугацаанд хийж гүйцэтгэсэн болно. Монгол Улсын төсвийн нээлттэй байдлыг үнэлэх судалгааг хийхэд Нээлттэй Нийгэм Форумын судлаачид хамтран ажилладаг.

Дэлхийн 100 гаруй орны төв засгийн газрын төсвийн ил тод байдлыг үнэлдэг “Нээлттэй төсвийн судалгаа”-г АНУ-д төвтэй Олон улсын төсвийн түншлэл байгууллагаас зохион байгуулдаг. “Нээлттэй төсвийн судалгаа” нь төв засгийн газар төсвийн найман гол баримт бичгийг олон нийтэд шуурхай ил тод болгосон байдал, мөн эдгээр баримт бичигт багтсан мэдээллийн иж бүрэн болон ач холбогдолтой байдалд үнэлгээ өгдөг. Үнэлгээг Олон Улсын Валютын сан, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага, Олон Улсын Аудитын дээд байгууллага зэрэг олон улсын байгууллагуудын боловсруулсан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгуурт тулгуурласан 109 үзүүлэлтийн дагуу хийж, нэгдсэн индекс гаргадаг. Судалгаанд хамрагдсан улс орон тус бүрийг 100 хүртэлх оноогоор үнэлж, төсвийн нээлттэй байдлын цорын ганц хараат бус харьцуулалтын хэмжүүр болох Нээлттэй төсвийн индексээр эрэмбэлдэг.

Төсвийн найман гол баримт бичиг

1	Төсвийн хүрээний мэдэгдэл	5	Жилийн явцын тайлангууд
2	Гүйцэтгэх засаглалын төсвийн санал	6	Хагас жилийн тойм
3	Батлагдсан төсөв	7	Жилийн эцсийн тайлан
4	Иргэдэд зориулсан төсөв	8	Аудитын тайлан

Судалгааны дүнтэй холбоотой нэмэлт мэдээллийг Олон улсын төсвийн түншлэл байгууллагаас эрхэлдэг www.openbudgetsurvey.org болон Нээлттэй Нийгэм Форумын www.forum.mn цахим хуудаснаас авна уу.

Нэмэлт тодруулга шаардлагатай бол Нээлттэй Нийгэм Форумын менежер Д. Оюунбадамд (Утас: 313207) хандана уу.